



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/45

Мөрөн сум

Иргэний газар өмчлөх эрхийг дуусгавар болгож, гэр бүлийн гишүүнд өмчлүүлэх, газрын байршил, талбайн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 5 дугаар зүйлийн 5.1.4, 7 дугаар зүйлийн 7.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 31 дүгээр зүйлийн 31.1.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өмчийн газраа бусад гэр бүлийн иргэний өмчлөлд шилжүүлэх өргөдөл гаргасан нэр бүхий 3 иргэний газар өмчлөх эрхийг дуусгавар болгож, 1 иргэнд тухайн газрыг өмчлүүлж, 5 иргэний нийт 3392м² газарт кадастрын мэдээллийн санд байгаа талбай хэмжээ, байршлаар нь өөрчлөлт оруулж хавсралт ёсоор баталсугай.

2. Хувийн хэргийн бүрдүүлэлтийг ханган, өмчилсөн газрыг улсын бүртгэлд бүртгэж мэдээллийн санд өөрчлөлтийг тусган захиргааны актыг оролцогчдод мэдэгдэхийг Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-д эрхийн баталгаанд өөрчлөлт хийхийг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус даалгасугай.

3. Аймгийн Засаг даргын энэхүү шийдвэрийг оролцогчид эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4. Газар өмчлөгчийн үүргийн биелэлтэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Мөрөн сумын Засаг дарга (Х.Тайванбаяр)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

6713010146

Захирамж2024

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 05 -ний өдрийн
А/45 дугаар захирамжийн хавсралт

ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХИЙН БАЙРШИЛ, ТАЛБАЙН ХЭМЖЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ӨМЧЛүүлсэн ЖАГСААЛТ

№	Захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй		Өмчлөгчийн			Өмчлөгчид	Цуцалсан өмчлөгчийн		Шинээр өмчлөгчийн	Өмчилсэн газрын өөрчлөлт		Нэгж талбарын дугаар	Тайлбар
	Огноо дугаар	2	Ургийн овог	Овог нэр /регистр/	Газрын байрши		Овог, эцэг /эх/-ийн нэр,	Регистр		Овог, эцэг /эх/-ийн	Кадас /мөн.		
0	1	2	3	4	5	6	8	9	10	11	12	13	14
1	2003.08.2 1 №189	10 дахь мөр	Боржигон	Очирбатын Мөнхбат РЮ69070872	6.41.4	360	О.Мөнхбат М.Оюунбат М.Оюундарь	РЮ69070872 РД92112238 РЗ94032003	Боржигон Рэнчин Отгонжаргал	591	1773	6712003486	Гэр бүлийн гишүүнд өмчлүүлж, газрын хэмжээг кадастрын зургийн дагуу өөрчилсөн
2	2004.06.2 2 №123	24 ын 8 дахь багана	Тогрууган	Жигжид Даваасүрэн	6.7.5	432				655	1965	6712018721	Газрын хэмжээг кадастрын зургийн хэмжээний дагуу өөрчилсөн
3	2012.03.1 3 А/61	32 ын 8 дахь багана	Хурмаст	Балдан Хүчит РС70022317	14.30.9	426				603	1809	6712013858	Газрын хэмжээг кадастрын зургийн хэмжээний дагуу өөрчилсөн

Handwritten signature

Газрын хэмжээг кадастрын зургийн хэмжээний дагуу өөрчилсөн	Газрын хэмжээг кадастрын зургийн хэмжээний дагуу өөрчилсөн
Газрын хэмжээг кадастрын зургийн хэмжээний дагуу өөрчилсөн	Газрын хэмжээг кадастрын зургийн хэмжээний дагуу өөрчилсөн